



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 28 (409)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Даатгалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай*

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Монгол Улсын 2006 оны төсвийн хүрээний мэдэгдлийг зөвшөөрөх тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Үндэсний сурын харваачдад цол олгох тухай*
- *Улсын далай аварга цол олгох тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Их ойн жил болгох тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2005 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ  
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2005 оны долоодугаар сарын 25

№28 (409)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

861.	Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	618
862.	"Малын индексжүүлсэн даатгал төсөл"-ийн хөгжлийн зээлийн гэрээг соёрхон батлах тухай	618
863.	Даатгалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	618
864.	Зүүн өмнөд Азийн найрамдал, хамтын ажиллагааны гэрээнд нэгдэн орсныг соёрхон батлах тухай	618

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

865.	Улсын Их Хурлын 65 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах тухай	Дугаар 44	618
866.	Нөхөн сонгуулийн зардлын хэмжээ тогтоох тухай	Дугаар 45	619
867.	Тогтоолд нэмэлт оруулах тухай	Дугаар 46	619
868.	Монгол Улсын 2006 оны төсвийн хүрээний мэдэгдлийг зөвшөөрөх тухай	Дугаар 47	619
869.	Төрийн ордон, түүний орчныг тохижуулахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 49	620

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

870.	Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай	Дугаар 16	620
871.	Т. Билэгтийг албан тушаалд томилох тухай	Дугаар 17	623
872.	М. Алтанхуягийг улируулан томилох тухай	Дугаар 18	623
873.	Үндэсний сурын харваачдад цол олгох тухай	Дугаар 19	623
874.	Улсын начин цол олгох тухай	Дугаар 20	624
875.	Улсын харцага цол олгох тухай	Дугаар 21	624
876.	Улсын заан цол олгох тухай	Дугаар 22	624
877.	Улсын далай аварга цол олгох тухай	Дугаар 23	625

### Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

878.	Их ойн жил болгох тухай	Дугаар 120	625
879.	Ажилд түр томилох тухай	Дугаар 123	625
880.	Дүрэм хүчингүй болсонд тооцох тухай	Дугаар 126	626
881.	Стандартчилал, тохирлын үнэлгээний ажлыг боловсронгуй болгох зарим арга хэмжээний тухай	Дугаар 127	626



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 7 дугаар сарын 7-ны өдөр

Улаанбаатар хот

### ЗАРИМ БАРААНД НОГДУУЛАХ ЭКСПОРТЫН ГААЛИЙН ТАТВАРЫН ХЭМЖЭЭ ТОГТООХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хуулийн 1 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 7 дугаар сарын 7-ны өдөр

Улаанбаатар хот

### "МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛ ТӨСӨЛ"-ИЙН ХӨГЖЛИЙН ЗЭЭЛИЙН ГЭРЭЭГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улс, Олон улсын хөгжлийн ассоциацийн хооронд 2005 оны 6 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан "Малын индексжүүлсэн даатгал төсөл"-ийн Хөгжлийн зээлийн гэрээг Монгол Улсын Засгийн газрын өргөн

мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 7 дугаар сарын 8-ны өдөр

Улаанбаатар хот

### ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Даатгалын тухай хуулийн 12.1-д заасан даатгалын үйл ажиллагаанд хяналт тавих эрхийг Санхүүгийн зохицуулах хороо байгуулагдах хүртэл Сангийн сайд /Н. Алтанхуяг/-

д олгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 7 дугаар сарын 8-ны өдөр

Улаанбаатар хот

### ЗҮҮН ӨМНӨД АЗИЙН НАЙРАМДАЛ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭНД НЭГДЭН ОРСНЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Зүүн өмнөд Азийн Найрамдал, хамтын ажиллагааны гэрээнд Монгол Улс нэгдэн орсныг Засгийн газрын өргөн

мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2005 оны 7 дугаар сарын 7-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 44

### Улсын Их Хурлын 65 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 42 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 65 дугаар тойрогт явуулах нөхөн сонгуулийн санал хураалтыг 2005 оны 8 дугаар сарын 28-ны өдөр явуулахаар тогтоосугай.

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 65 дугаар тойрогт явуулах нөхөн сонгуулийг 2005 оны 7 дугаар сарын 15-ны өдрөөс товлон зарласугай.

3. Энэ тогтоолыг 2005 оны 7 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2005 оны 7 дугаар сарын 7-ны өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот

### Нөхөн сонгуулийн зардлын хэмжээ тогтоох тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

санхүүжүүлэхийг Засгийн газар /Ц.ЭЛБЭГДОРЖ/-т даалгасугай.

2. Энэ тогтоолыг 2005 оны 7 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 65 дугаар тойрогт явуулах нөхөн сонгуулийг улсын төвлөрсөн төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг 5273400 /таван сая хоёр зуун далан гурван мянга дөрвөн зуун/ төгрөгөөр тогтоож, уг зардлыг Засгийн газрын хуваарилагдаагүй хөрөнгөөс

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2005 оны 7 дугаар сарын 7-ны өдөр

Дугаар 46

Улаанбаатар хот

### Тогтоолд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Их Хурлын 1998 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох бүлэг барааны жагсаалтад дор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмсүгэй.

1. Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай Монгол Улсын

№	Бүлэг барааны бичиглэл	Улсын хилээр нэвтрэх ялгаа
3	Хаягдал хар болон өнгөт төмөрлөг /ширэм, төмөр, ган, зэс, гууль, хөнгөн цагаан, тэдгээрийн хайлш/, цутгамал болон анхдагч бусад хэлбэртэй хар болон өнгөт төмөрлөг, зориулалтын дагуу ашиглагдахгүй байгаа хар болон өнгөт төмөрлөгөөр хийсэн сэлбэг, бүтээгдэхүүн	Гаргах

2. Энэ тогтоолыг 2005 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2005 оны 7 дугаар сарын 7-ны өдөр

Дугаар 47

Улаанбаатар хот

### Монгол Улсын 2006 оны төсвийн хүрээний мэдэгдлийг зөвшөөрөх тухай

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 6.1.2 дахь заалт, 25 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

баримтлахыг Засгийн газар /Ц.Элбэгдорж/-т үүрэг болгосугай.

1. Монгол Улсын 2006 оны төсвийн хүрээний мэдэгдлийг хавсралтаар зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засгийн байнгын хороо /Ц.Дамиран/, Төсвийн байнгын хороо /Р.Бадамдамдин/-нд тус тус даалгасугай.

2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2006 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Монгол Улсын 2006 оны төсвийн хуулийн төслийг боловсруулахдаа Төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүдийг

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ



## Монгол Улсын Их Хурлын 2005 оны 47 дугаар тогтоолын хавсралт

### МОНГОЛ УЛСЫН 2006 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ

1. ДНБ-ний бодит өсөлтийн доод хэмжээ, хувь	7.6
2. Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн өсөлтийн дээд хэмжээ, хувь	5.0
3. Төсвийн нийт орлогын ДНБ-д эзлэх доод хэмжээ, хувь	36.1
4. Төсвийн нийт зарлагын ДНБ-д эзлэх дээд хэмжээ, хувь	40.4
5. Төсвийн урсгал тэнцлийн ДНБ-д эзлэх доод хэмжээ, хувь	7.6
6. Төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх дээд хэмжээ, хувь	-4.0
7. Хөрөнгө оруулалтын зардлын ДНБ-д эзлэх дээд хэмжээ, хувь	5.6
8. Төсөвт байгууллагад ажиллагчдын цалингийн сангийн ДНБ-д эзлэх дээд хэмжээ, хувь	6.8

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2005 оны 7 дугаар  
сарын 8-ны өдөр

Дугаар 49

Улаанбаатар  
хот

#### Төрийн ордон, түүний орчныг тохижуулахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрийн ордон, түүний орчныг шинэчлэн тохижуулах, "Монгол төрийн тамга" бэлэгдлийн хөшөө байгуулахтай холбогдуулан Ж. Самбуугийн шарилыг Төрийн ордны ард байрлах Ардын хувьсгалын талбайгаас Алтан-Өлгийд шилжүүлэн байршуулсугай.

2. Ж. Самбуугийн шарилыг ёслол хүндэтгэлтэйгээр шилжүүлэн байршуулж, дурсгалын хөшөө байгуулах ажлыг зохион байгуулахыг Засгийн газар /Ц.Элбэгдорж / - т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 7 дугаар  
сарын 8-ны өдөр

Дугаар 16

Улаанбаатар  
хот

#### Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэрлэл, үйлчилгээ, боловсрол, соёл урлаг, эрүүл мэнд, банк, авто тээвэр, хэвлэл мэдээлэл, төр захиргааны болон төрийн бус

байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

#### ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Алдарын Ендон-Улсын ардын дуу, бүжгийн эрдмийн чуулгын ахмад бүжигчин

5. Төгсийн Пүрэвдорж-Нийслэлийн Нийтийн тээвэр зохицуулалтын газрын дарга

2. Намсрайжавын Лувсанжав-Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга

6. Загарын Төмөрбаатар-Түлш, эрчим хүчний яамны Түлшний бодлого зохицуулалтын газрын дарга

3. Халзхүүгийн Наранхүү-Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн ерөнхий захирал

7. Чагнаадоржийн Ухнаа-Улсын клиникийн нэгдсэн 2 дугаар эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн дэд захирал

4. Санжаасүрэнгийн Оюун-Монгол Улсын Их Хурлын гишүүн

8. Халтарын Шаандар-Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн ахлах референт

**ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН  
ОДОНГООР:**

Дүйнхоржавын Баянжав-ЗХЖШ-ын хэлтсийн  
орлогч дарга, хурандаа

**"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:**

1. Доржийн Бат-Очир- Нийслэлийн авто  
тээврийн "Хорин хоёрдугаар бааз" ХК-ийн жолооч

16. Гончигцэрэнгийн Нацагням-Нийслэлийн  
мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагч

2. Загдын Биндэръяа-ШУТИС-ийн Барилгын  
инженерийн сургуулийн захирал

17. Чулуунбаатарын Однасан-Нийслэлийн  
Өмчийн харилцааны газрын бүртгэл, хяналтын  
хэлтсийн дарга

3. Дарамын Ганбаатар- Нийслэлийн  
Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн  
салбар амбулаторийн эрхлэгч

18. Дармаагийн Сайнбаяр- "Өнөөдөр" сонины  
сурвалжлагч, тоймч

4. Айрковын Ганболд- Нийслэлийн авто  
тээврийн "Тав" ХК-ийн жолооч

19. Дондогийн Сундуйжав- Нийслэлийн  
Засаг даргын Тамгын газрын Авто баазын инженер  
механик

5. Нямдондовын Ганболд- Монголын  
Тэшүүрийн холбооны дасгалжуулагч

20. Жигжжавын Төмөрбаатар- Орхон аймаг  
дахь Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах  
"Эрдэнэт" үйлдвэрийн авто тээврийн байгууллагын  
автозасварын газрын дарга

6. Цээхүүгийн Ганхүү- Нийслэлийн Эрүүл  
мэндийн газрын дарга

21. Булчулууны Тэрбиш- Өвөрхангай аймаг  
дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн  
мэдрэлийн зөвлөх эмч

7. Бадамдоржийн Ганчимэг- "Өдрийн  
сонин"-ы тоймч, сэтгүүлч

22. Жамсранжавын Уранбилэг- Нийслэлийн  
Нийтийн тээвэр зохицуулалтын газрын тамгын  
хэлтсийн дарга

8. Лхагвасүрэнгийн Даваасамбуу-Хил  
хамгаалах ерөнхий газрын санхүү бүртгэлийн  
хэлтсийн дарга

9. Баярмагнайн Дашдондог- "Мюзик соунд"  
студийн захирал, эстрадын дуучин

23. Чимээгийн Үржээ- Нийслэлийн  
мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагч

10. Гонгоосүрэнгийн Долгор-Нийслэлийн  
эрүүл мэндийн "Энх-Ундарга" мэдрэлийн хувийн  
эмнэлгийн ерөнхий эмч

24. Гунгаагийн Халтар- МҮЭ-ийн Соёлын  
төв ордны санхүү аажухуйн албаны дарга, ерөнхий  
санхүүч

11. Цэрэнпилийн Жамсранжав-Хэнтий  
аймгийн Дадал сум дахь модон эдлэл, барилгын  
"Балжаан" ХХК-ийн захирал

25. Дамдингийн Цоодол- Монголын  
үндэсний телевизийн нэвтрүүлэгч

12. Адъяаагийн Зоригтбаатар- Зам тээвэр,  
аялал жуулчлалын яамны Тээврийн үйлчилгээний  
төвийн тээвэр зохицуулагч

26. Нүрээдийн Цэрэндолгор-Нийслэлийн  
худалдаа, үйлчилгээний "Алтжин групп"-ийн  
жолооч- борлуулагч

13. Янжинжавын Марууш-Монголын хувийн  
хэвшлийн үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны  
зохион байгуулагч

27. Саранцэцэгийн Чимгээ-Монголын  
үндэсний телевизийн нэвтрүүлэгч

14. Нямжанцангийн Мягмарсүрэн- "Дулааны  
3 дугаар цахилгаан станц" ХК-ийн гүйцэтгэх захирал

28. Дадалын Энхтуяа-Монголын үндэсний  
телевизийн "ММ" агентлагийн ерөнхий редактор

15. Доржийн Насанжаргал-Монгол Улсын Их  
Хурлын Тамгын газрын зөвлөх

29. Дондогдоржийн Эрдэнэбаг- Нийслэлийн  
Багануур дүүргийн Ардчилсан намын дарга, Ноён  
групийн ерөнхий захирал

**ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ ОДОНГООР:**

Нэмхайн Лхагвадорж-БХИС-ийн Ахлагчийн  
коллежийн захирал, дэд хурандаа



## ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Балдоржийн Алтангэрэл-Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн авто тээврийн байгууллагын БелАЗын жолооч
2. Пүрэвийн Баасанжав-Нийслэлийн Баянгол дүүргийн 10 жилийн 47 дугаар сургуулийн бага ангийн багш
3. Должингийн Баатарсайхан-Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн референт
4. Дашдоржийн Бадраа- Улаанбаатар хотын банкны гүйцэтгэх захирал
5. Дуузын Басбиш- Улс хоорондын тээвэр зуучийн "Туушин" ХХК-ийн жолооч
6. Чимэддоржийн Батсүх- Дархан-Уул аймгийн Дархан сумын 20 дугаар сургуулийн зөвлөх багш
7. Гомбожавын Баяжих- Булган аймгийн Баян-Агт сумын Баянзүрх багийн Засаг дарга
8. Түвдэнгийн Баярбат- Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн авто тээврийн байгууллагын засварчин
9. Цэрэнчимэдийн Баярсайхан-Хөвсгөл аймгийн Бүрэнхааны улсын асрамжийн газрын дарга
10. Доржсүрэнгийн Болдбаатар-Гадаад хэлний "Гэгээ" коллежийн багш
11. Гомбын Гансүрэн- Нийслэлийн Өмчийн харилцааны газрын мэргэжилтэн
12. Дагвын Гүнбазар-Улсын мэргэжлийн хяналтын газрын дэд бүтцийн хяналтын хэлтсийн дарга
13. Шагдарсүрэнгийн Даваа-Үндэсний дуу, бүжгийн эрдмийн чуулгын хөгжимчин
14. Лувсандагвын Даваадулам- Дархан-Уул аймгийн Мэргэжлийн хяналтын газрын тасгийн дарга
15. Содномын Дагва- Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн авто тээврийн байгууллагын автобусны жолооч
16. Цэрэндуламын Дашиймаа-Зам тээвэр, аялал жуулчлалын яамны Тээврийн үйлчилгээний төвийн тээвэр зохицуулагч
17. Ёндонсүрэнгийн Жаргалсайхан- Зам тээвэр, аялал жуулчлалын яамны Тээврийн бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн
18. Цэрэнбалжирын Лхагвамаа- Баянхонгор аймгийн Богд сумын 10 жилийн сургуулийн багш
19. Ёндонсамбуугийн Лхагвацэрэн- Нийслэлийн Хан-Уул дүүргийн математикийн гүнзгийрүүлсэн сургалттай 10 жилийн 32 дугаар сургуулийн нийгмийн ажилтан
20. Пүрэвийн Лхамсүрэн-Нийслэлийн Хан-Уул дүүргийн Тохижилт үйлчилгээний компанийн жолооч
21. Дамдингийн Лувсангомбо-Нийслэлийн нийтийн зорчигч тээврийн "Автобус-2" компанийн жолооч
22. Жоноогийн Мандах- Баянхонгор аймгийн Богд сумын 10 жилийн сургуулийн багш
23. Оршихийн Налжирмаа- Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагч
24. Бэгзсүрэнгийн Оюунсүрэн-Нийслэлийн Өмчийн харилцааны газрын мэргэжилтэн
25. Гомбосүрэнгийн Оюунцэцэг-Үндэсний статистикийн газрын гадаад харилцааны хэлтсийн дарга
26. Гонгорын Оюунчимэг-"Дулааны 3 дугаар цахилгаан станц" ХК-ийн бутлагчийн машинч
27. Гэнэнгийн Содном- Увс аймгийн Давст сумын Засаг даргын Тамгын газрын дарга
28. Гэндэнпилийн Төмөр-Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ИТХТ-ийн нарийн бичгийн дарга
29. Шагдарсүрэнгийн Цагаандолгор-Соёлын коллежийн монгол хэл, уран зохиолын багш
30. Жанцансамбуугийн Цэндсүрэн- Үйлдвэрлэл, Урлалын дээд сургуулийн багш
31. Нийвийдийн Цэрэндаш- Нийслэлийн авто тээврийн "Хорин хоёрдугаар бааз" ХК-ийн жолооч
32. Балдангийн Цэцэгмаа-Нийслэлийн Баянзүрх дүүргийн 82 дугаар цэцэрлэгийн багш
33. Ламжавын Энхбаяр-Нийслэлийн авто тээврийн "Тав" ХК-ийн жолооч
34. Нацагдоржийн Эрдэнэ- Нийслэлийн математикийн гүнзгийрүүлсэн сургалттай "Номуун" дунд сургуулийн захирал
35. Жигмэддоржийн Эрдэнэцогт- Дорнод аймгийн "Дулааны цахилгаан станц" ХК-ийн ерөнхий инженер
36. Гунгаагийн Эрдэнэцэцэг- Үндэсний статистикийн газрын Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн
37. Чимидийн Ядамсүрэн-Шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн электрон техник, машин судлалын нэгдлийн лабораторийн эрхлэгч



## ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Базарын Амаржаргал-Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн харъяа 148 дугаар салбарын захирагч, хошууч

3. Дансрангийн Ганхүү-Зэвсэгт хүчний Клиникийн төв госпиталийн рентгений их эмч, хошууч

2. Пунцагнамжилын Баярсайхан-Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн машины дарга, жолооч, ахлах ахлагч

4. Лхамаагийн Гүнтэвсүрэн-Замын цагдаагийн газрын Замын зохион байгуулалт хяналтын тасгийн ахлах байцаагч

## “ЭНХИЙН ТӨЛӨӨ” МЕДАЛИАР:

Жигжидийн Батсүх- Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн нислэгийн ахлах удирдагч, дэд хурандаа

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ Дугаар 17

2005 оны 7 дугаар сарын 8-ны өдөр

Улаанбаатар хот

### Т. Билэгтийг албан тушаалд томилох тухай

“Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын албан хууль”-ийн 17 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тушаалд томилсугай. баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Түдэвийн Билэгтийг Монгол Улсын

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ Дугаар 18

2005 оны 7 дугаар сарын 8-ны өдөр

Улаанбаатар хот

### М. Алтанхуягийг улируулан томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин прокурорын албан тушаалд улируулан томилсугай. зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монголын Алтанхуягийг Улсын ерөнхий

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ Дугаар 19

2005 оны 7 дугаар сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

### Үндэсний сурын харваачдад цол олгох тухай

“Үндэсний их баяр наадмын тухай” Монгол эмэгтэйчүүдийн харваанд түрүүлсэн Дорнод Улсын хуулийн гуравдугаар бүлгийн 9 дүгээр аймгийн харъяат, “Бурхан халдун” групп, Автобус-III компанийн харваач Хишигтийн Даваажаргалд зүйлийн 2 дугаар заалт болон Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны саналыг улсын даяар дуурсах мэргэн цол тус тус олгосугай. үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Үндэсний их баяр наадам, Монгол Ардын хувьсгалын 84 жилийн ойн баярын үндэсний сурын эрэгтэйчүүдийн харваанд түрүүлсэн Баян-Өлгий аймгийн харъяат, Цагдаагийн академийн харваач Аюушийн Хонгорт улсын мэргэн цол,

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР





## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 7 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

### Улсын начин цол олгох тухай

"Үндэсний их баяр наадмын тухай" Монгол Улсын хуулийн гуравдугаар бүлгийн 7 дугаар зүйлийн 1 дүгээр заалт болон Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Үндэсний их баяр наадам, Монгол Ардын хувьсгалын 84 жилийн ойн баярын хүчит бөхийн барилдаанд 5 давсан дараахь бөхчүүдэд улсын начин цол олгосугай.

1. Цэрэндашийн Цогтжаргал -Булган аймгийн Гурванбулаг сумын харьяат, "Хилчин" дэвжээний бөх

2. Мөнхбаярын Цанлиг- Архангай аймгийн Тариат сумын харьяат, "Есөн туг" клубийн бөх

3. Даш-Очирын Батболд-Баянхонгор аймгийн Баянбулаг сумын харьяат, "Тэрэлж жуулчин" компанийн бөх

4. Дашзэвгийн Баасандорж- Булган аймгийн Бүрэгхангай сумын харьяат, "Хилчин" дэвжээний бөх

5. Түмэннасангийн Амартүвшин-Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын харьяат, "Хүч" спортын хорооны бөх

6. Батсүхийн Насандэлгэр-Увс аймгийн Сагил сумын харьяат, "Хүрд" ХХК- ийн бөх

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 7 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

### Улсын харцага цол олгох тухай

"Үндэсний их баяр наадмын тухай" Монгол Улсын хуулийн гуравдугаар бүлгийн 7 дугаар зүйлийн 1 дүгээр заалт болон Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Үндэсний их баяр наадам, Монгол Ардын хувьсгалын 84 жилийн ойн баярын хүчит бөхийн барилдаанд 6 давсан Архангай аймгийн Булган

сумын харьяат, "Макс" группийн бөх Дамбийгийн Рагчаад улсын харцага цол олгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 7 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

### Улсын заан цол олгох тухай

"Үндэсний их баяр наадмын тухай" Монгол Улсын хуулийн гуравдугаар бүлгийн 7 дугаар зүйлийн 1 дүгээр заалт болон Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Үндэсний их баяр наадам, Монгол Ардын хувьсгалын 84 жилийн ойн баярын хүчит бөхийн барилдаанд 7 давсан Ховд аймгийн Мест сумын харьяат, "Хүч" спортын хороо, "Пума" группийн бөх Цэдэвийн Мянгарсүрэн, Хөвсгөл аймгийн Шинэ-

Идэр сумын харьяат, "Аварга" дээд сургуулийн бөх Хадбаатарын Мөнхбаатар нарт улсын заан цол олгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

 2005 оны 7 дугаар  
сарын 12-ны өдөр

Дугаар 23

 Улаанбаатар  
хот

### Улсын далай аварга цол олгох тухай

"Үндэсний их баяр наадмын тухай" Монгол Улсын хуулийн гуравдугаар бүлгийн 7 дугаар зүйлийн 1 дүгээр заалт болон Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Үндэсний их баяр наадам, Монгол Ардын хувьсгалын 84 жилийн ойн баярын хүчит бөхийн барилдаанд 9 давж түрүүлсэн Архангай аймгийн Батцэнгэл сумын харъяат, "Алдар" спорт хороо,

"Бридж" группийн бөх Гэлэгжамцын Өсөхбаярт улсын далай аварга цол олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**
**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

 2005 оны 6 дугаар  
сарын 8-ны өдөр

Дугаар 120

Улаанбаатар хот

### Их ойн жил болгох тухай

Монгол Улсын Тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ойн арга хэмжээг бэлтгэх, тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг удирдан зохион байгуулах Үндэсний хорооны саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ой тэмдэглэхтэй холбогдуулан 2006 оныг "Их ойн жил" болгон зарласугай.

2. "Их ойн жил"-ийн хүрээнд хийх ажил, зохиох арга хэмжээний төлөвлөгөөг батлан ажиллаж, үр дүнг 2006 оны 12 дугаар сард Засгийн газарт танилцуулахыг Үндэсний хороонд даалгасугай.

3. Их ойг тэмдэглэх зардлын эх үүсвэрийг 2006 оны улсын төсөвт тусгаж санхүүжүүлэхийг Сангийн сайд Н.Алтанхуягт даалгасугай.

4. "Их ойн жил"-ийн хүрээнд орон нутгийн хэмжээнд хийх ажил, зохиох арга хэмжээг тусгай төлөвлөгөөний үндсэн дээр зохион байгуулан хэрэгжүүлж явц, үр дүнг Үндэсний хороонд танилцуулж байхыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Монгол Улсын Тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэн ажиллахыг нийт аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд уриалсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**
**Ц.ЭЛБЭГДОРЖ**
**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА С.БАЯРЦОГТ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

 2005 оны 6 дугаар  
сарын 8-ны өдөр

Дугаар 123

Улаанбаатар хот

### Ажилд түр томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18<sup>д</sup> дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 17.12-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Тогоочийн Лхагвааг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Удирдлагын академийн

захирлаар түр томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**
**Ц.ЭЛБЭГДОРЖ**
**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА С.БАЯРЦОГТ**



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 6 дугаар сарын 13-ний өдөр

Дугаар 126

Улаанбаатар хот

*Дүрэм хүчингүй болсонд тооцох тухай*

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь: болсонд тооцусгай.

Засгийн газрын 1999 оны 149 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Өрхийн эмнэлгийн үлгэрчилсэн дүрэм"-ийг хүчингүй

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД** **Ц.ЭЛБЭГДОРЖ**  
**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД** **Т.ГАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 6 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 127

Улаанбаатар хот

*Стандартчилал, тохирлын үнэлгээний ажлыг боловсронгуй болгох зарим арга хэмжээний тухай*

Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 16.1, 16.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

6. Засгийн газрын 2003 оны 222 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Тохирлын баталгаатай бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нийлүүлэх, хилээр нэвтрүүлэх журам"-д дараахь нэмэлт оруулсугай:

1. Тохирлын баталгаанд заавал хамрагдах бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний жэгсаалтыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

Журмын 3.1-д "3.1.1. Энэ журмын 2.12, 3.8-д заасан бүтээгдэхүүнийг аливаа нэмэлт баримт бичиг шаардахгүйгээр нэвтрүүлнэ; 3.1.2. Экспортлогч, импортлогч талын хүсэлтээр энэ журмын 2.12, 3.8-д заасан экспортын бүтээгдэхүүнд баталгаажуулалтын байгууллага тохирлын гэрчилгээ олгож болно; 3.1.3. Жагсаалтад орсон бөгөөд энэ журмын 3.1.1-д заасан нөхцөлийг хангаагүй бүтээгдэхүүнд зөвхөн 3.2-ыг үндэслэн тохирлын гэрчилгээ олгоно," гэж, 2.19-ийн "үйлдвэрлэгч/нийлүүлэгч..." гэсний дараа "жагсаалтад заасан холбогдох" гэж, 3.7-гийн "... худалдааны ..." гэсний дараа "болон бусад" гэж, "... тусгасан ..." гэсний дараа "буюу хүлээн авагч талаас шаардсан" гэж тус тус нэмсүгэй.

2. Сорилт, шинжилгээ, хэмжил зүйн үйл ажиллагаа эрхэлдэг хөндлөнгийн лабораториудыг аттестатчилж, энэ чиглэлийн ажил, үйлчилгээг "нэг цэг"-ийн зарчимд шилжүүлэх болон стандарт, техникийн зохицуулалт, тохирлын баримт бичгийн үндэсний мэдээллийн сүлжээ бий болгох арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд Д.Дорлигжав, Стандартчилал, хэмжил зүйн төвийн дарга Н.Жанчивдорж, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Бараа, бүтээгдэхүүнд "эко" тэмдэг хэрэглэх стандартыг тогтоон хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Байгаль орчны сайд У.Барсболд, Стандартчилал, хэмжил зүйн төвийн дарга Н.Жанчивдорж нарт үүрэг болгосугай.

4. Монгол Улсын үндэсний тохирлын тэмдэг, түүнтэй адилтгах тэмдэгтэй бараа, бүтээгдэхүүнээс бусад бараа, бүтээгдэхүүнд тавих хяналтыг сайжруулахыг Монгол Улсын сайд Д.Дорлигжавт үүрэг болгосугай.

7. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2003 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 222 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцусгай.

5. Тохирлын болон түүнтэй адилтгах тэмдэг, гэрчилгээтэй нийлүүлэх бараа, бүтээгдэхүүний жэгсаалтыг харилцан хүлээн зөвшөөрөх асуудлаар олон улсын байгууллага, гадаад орнуудтай гэрээ, хэлэлцээр байгуулах ажил зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайд Ч.Улаан, Үйлдвэр, худалдааны сайд С.Батболд, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Тэрбишдагва, Монгол Улсын сайд Д.Дорлигжав нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД** **Ц.ЭЛБЭГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН  
ШАДАР САЙД** **Ч.УЛААН**

**ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ  
САЙД** **С.БАТБОЛД**

## ТОХИРЛЫН БАТАЛГААНД ЗААВАЛ ХАМРАГДАХ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ

### А. Бүтээгдэхүүн:

Бүлэг №	Зүйл №	Мөр	Үндэсний код	Барааны бичиглэл
02				Мах, хүнсний дайвар бүтээгдэхүүн
04	04.02			Саахар болон бусад амтлагчийн хольцтой өтгөрүүлсэн сүү, цөцгий
	04.03	0403.10	00	Йогурт
	04.05			Цөцгийн тос, сүүнээс гаргаж авсан бусад тос, өтгөн цөцгий
	04.06			Бяслаг ба аарц
05	05.04			Мал, амьтны /загаснаас бусад/ шинэ, хөргөсөн, хөлдөөсөн, давсалсан, давсны уусмалд хадгалсан, хатаасан, утсан бүтэн буюу хуваасан өлөн гэдэс
09	09.01			Хуурсан буюу хуураагүй, кофеиноос цэвэрлэсэн буюу цэвэрлээгүй кофе, кофеиний хальс, яс, тодорхой хэмжээний кофеиний агуулгатай кофег орлодог бүтээгдэхүүн
	09.02			Амт, үнэр оруулсан буюу оруулаагүй /ферментжүүлсэн буюу ферментжүүлээгүй/ цай
11	11.01	1101.00		Улаан буудайн буюу улаан буудай-хөх тарианы гурил
	11.02	1101.00		Улаан буудайн буюу улаан буудай-хөх тарианы гурилаас бусад үр тарианы гурил
	11.04			Бусад аргаар боловсруулсан үр тарианы будаа /жишээ нь: цэвэрлэсэн, өнхрүүлэгт оруулсан, хальсалсан, буталсан, жижиглэсэн /нунтагласан/ үр тарианы үр хөврөл /нягтруулсан, хөвсийлгөсөн, нунтагласан/

15				Мал, амьтны болон ургамлын гаралтай тос, түүнийг задалж боловсруулсан бүтээгдэхүүн, идэшний тос, мал, амьтан, ургамлын гаралтай лав
16	16.01			Мах, дайвар мах буюу цусан хиам, түүнтэй төстэй бүтээгдэхүүн, тэдгээрээр хийсэн хүнсний бэлдмэл
	16.02			Мах, дайвар мах болон цусаар хийсэн бусад бэлдмэл, тэдгээрийн лаазалсан бүтээгдэхүүн
	16.04			Бэлдсэн буюу лаазалсан загас, загасны түрс буюу түүнийг орлох бүтээгдэхүүн
17				Саахар, саахаран бүтээгдэхүүн
19				Үр тариа, гурил, цардуул, сүүн бэлдмэл, гурилан бүтээгдэхүүн
21				Төрөл бүрийн хүнсний бэлдмэл
22				Ус, ундаа, спирт, архи, дарс, цуу
24				Тамхи, түүнийг орлуулагч бүтээгдэхүүн
25	25.01	2501.00		Хүнсний давс
		2501.00	11	Иоджуулсан
		2501.00	19	Бусад
	25.23			Өнгө оруулсан буюу оруулаагүй, клинкер хэлбэрт оруулсан буюу оруулаагүй портланд цемент, пуйлсаган цемент /хөнгөн цагаан цемент/, тусгай зориулалтын цемент, шаарган цемент, суперсульфатын цемент ба тэдгээртэй төстэй усжсан бусад цемент
27	27.01			Нүүрс, брикет, шахмал нүүрс болон нүүрснээс гаргаж авсан тэдгээртэй төстэй хатуу түлш -нунтагласан буюу нунтаглаагүй бөөмнөрүүлээгүй нүүрс

27	27.10	2710.00		Нефть ба битумжсэн эрдсээс гаргасан газрын тос /түүхий биш/, жингийн 70% буюу түүнээс их нефть буюу битумжсэн эрдсээс гаргасан газрын тос агуулсан, бусад газарт тусгайлан заагдаагүй буюу ороогүй бэлдмэл /эдгээр газрын тос нь бэлдмэлийн үндсэн бүрэлдүүлэгч хэсэг нь байна/
30	30.02	3002.20	00	Хүн эмнэлгийн зориулалттай вакцин
		3002.30	00	Мал эмнэлгийн зориулалттай вакцин
	30.03			Жижиглэн худалдаалах тун хэлбэрт савлагдаагүй, урьдчилан сэргийлэх буюу эмчилгээний зориулалттай хоёр буюу түүнээс дээш найрлагатай эмийн бэлдмэл /Зүйл 30.02, 30.05, 30.06-д зааснаас бусад/
	30.04			Жижиглэн худалдаалах тун хэлбэрт савлагдсан, урьдчилан сэргийлэх буюу эмчилгээний зориулалттай холимог буюу холимог бус эм /Зүйл 30.02, 30.05, 30.06-д зааснаас бусад/
32	32.08			Нийлэг буюу байгалийн хувиргасан полимерт суурилсан, усан биш орчинд уусгасан буюу булингажуулсан найруулсан будаг, чий /пак/ /пааландах будаг буюу маажин орно/, энэ бүлгийн 4 дүгээр зүйлд заасан уусмал
	32.09			Нийлэг буюу байгалийн хувиргасан полимерт суурилсан, усан орчинд уусгасан буюу булингажуулсан найруулсан будаг, чий /пак/ /пааландах будаг буюу маажиндах чий орно/
33	33.03	3303.00	00	Үнэртэй ус, ариун цэврийн ус
	33.04			Гоо сайхны бэлдмэл, биеийн арьс арчилж, хамгаалах бэлдмэл /эмийн бэлдмэлээс бусад наранд шарах ба нарнаас хамгаалах бэлдмэл орно/, хумс заслын бэлдмэл
	33.05			Үс арчлах бэлдмэл
	33.06			Амны хөндий, шүдний ариун цэврийн бэлдмэл, хиймэл шүд бэхжүүлэх нунтаг, шахмал оо, жижиглэн худалдаалах нэг бүрийн боодолтой шүдний мяндсан чигчлүүр



34	34.01	3401.11	00	Гар нүүрийн саван /эмийн бэлдмэлтэй бүтээгдэхүүн орно/
		3401.19	10	Эдийн саван
	34.02	3402.20	10	Жижиглэн худалдах зориулалтаар савласан бэлдмэл, угаалгын нунтаг
	34.02			Гадаргуугийн идэвхит органик бодис /савангаас бусад/, гадаргуугийн идэвхит бэлдмэл /туслах чанарын угаалгын бэлдмэл ба зүйл 34.01-д заагдсанаас бусад саван агуулсан буюу агуулаагүй цэвэрлэгээний бэлдмэл/
	34.04	3404.20	00	Полиэтилен гликолийн лав
36	36.02	3601.00	00	Дарь, тийрэлтэт түлш
	36.02	3602.00	00	Дарь, тийрэлтэт түлшнээс бусад тэсрэгч бэлдмэл
	36.03	3603.00	00	Гал дамжуулах аюулгүй утас, тэсэлгээний утас, цохилтын буюу тэсэлгээний бялтат бүрхүүл, ноцоогуур, цахилгаан тэслүүр
	36.04			Гэрэлтэн шатагч зүйлс, дохионы гэрэлт пуужин, аадар эсэргүүцэх, манантай үеийн дохиоллын пуужин, пиротехникийн бусад хэрэгсэл
39	39.17		Даралтад ажиллах хуванцар хоолой /цэвэр, бохир усны/	
41	41.04		Зүйл 41.08 буюу 41.09-д зааснаас бусад үсийг нь унагасан адуу, үхрийн шир	
48	48.03	4803.00	00	Гэр ахуй, ариун цэврийн зориулалттай гар нүүр, жорлонгийн цаас, цаасан алчуур, амны цаасан алчуур буюу тэдгээртэй төстэй цаас, гадаргууд нь хэв, атираа, нугалаас үүсгэсэн, нүхэлсэн, будсан, хээлж чимэглэсэн буюу ийм боловсруулалт хийгээгүй, хуудаслан зүссэн буюу хүйлмал хэлбэрийн, целлюлозон хөвөн ба целлюлозон зулмал
51	51.05		Сэмлэсэн буюу самнасан хонины ноос буюу мэл, амьтны нарийн буюу бүдүүн үс, ноос, хялгас /самнасан тайрмал ноос орно/	

68	68.06	6806.10		Гулдмай, хуудас буюу хуйлмал байдалтай шаарган хөвөн, эрдэс чулуун хөвөн ба тэдгээртэй төстэй эрдэс хөвөн /гэдгээрийн холимог орно/
		6806.10	10	Эрдэс хөвөн
	68.07			Асфальт буюу түүнтэй төстэй материал /нефтийн битум, чулуун нүүрсний давирхай/-аар хийсэн бүтээгдэхүүн
	68.08			Цемент, бетон, төмөр бетон, гөлтгөнө, бусад эрдэс материалын холбогчтой ургамлын мяндас, сүрэл, модны үртэс, зоргодос, зах зэрэг материалаар хийсэн хавтан, хавтанцар, гулдмай ба адил төстэй зүйлс
	68.10			Цемент, бетон болон хиймэл чулуун, хүчитгэсэн буюу хүчитгээгүй бүтээгдэхүүн
72	72.04			Хаягдал хар төмөр
	72.06			Цутгамал болон анхдагч бусад хэлбэртэй төмөр ба чанаржуулаагүй ган
	72.13			Халуунаар цувисан, зөв бус хэлбэрийн ороомог байдалтай төмөр буюу чанаржаагүй гангаар хийсэн цулдан ба туйван, бүх төрлийн ган арматур
	72.14			Давтах, халуунаар цувих, халуунаар сунгах болон даралтаар шахаж, цувихаас цаашид боловсруулалт хийгээгүй, цувисны дараа мушгисан төмөр буюу чанаржуулаагүй гангаар хийсэн бусад цулдан ба туйван
	72.15			Төмөр буюу чанаржуулсан гангаар хийсэн бусад цулдан ба туйван
	72.16			Төмөр буюу чанаржуулаагүй гангаар хийсэн булан хэлбэрт болон сортын төмөр
	73	73.03	7303.00	00
	73.04			Төмөр /ширэмнээс бусад/ буюу гангаар хийсэн, ширээсгүй, нарийн, бүдүүн хоолой ба хөндий огтолбор



	73.08			Төмөр хийц, түүний эд анги, төмөр буюу гангаар хийсэн төмөр хийц үйлдвэрлэх зориулалттай хавтан, туйван, булан хэлбэрт болон сортын төмөр хоолой ба тэдгээртэй төстэй зүйлс
	73.12			Татлагын ган тороос /сүлжмэл, томсон/
83	83.11			Ганнуурын электрод
84	84.19			Халаах хэрэгсэл
85	85.09			Өөртөө цахилгаан хөдөлгүүр бүхий гэр ахуйн зориулалтын цахилгаан-механик хэрэгсэл
95	95.02			Зөвхөн хүн дүрстэй хүүхэлдэй
	95.03			Бусад тоглоом, овор хэмжээ /масштаб/-г нь багасгасан загвар буюу түүнтэй төстэй зугаа цэнгээний хөдөлгөөнт буюу хөдөлгөөнт биш загвар, бүх төрлийн оньсон тоглоом.

Тайлбар: 1. Бүтээгдэхүүний технологийн шийдлийг зохицуулах зорилгоор гадаадын холбогдох сорилтын байгууллагад илгээж байгаа 10 кг хүртэлх жагсаалтад орсон бүтээгдэхүүнд экспортын барааны тохирлын гэрчилгээ олгохгүй.

2. Манай улсад үйл ажиллагаа явуулдаг татваргүй барааны дэлгүүрт нийлүүлж байгаа жагсаалтад орсон бүтээгдэхүүнд экспортын барааны тохирлын гэрчилгээ олгохгүй.

### Б. Үйлчилгээ:

1	Үсчин
2	Гоо сайхан
3	Халуун ус
4	Саун
5	Хими цэвэрлэгээ
6	Автомашинь оношилгооны болон засварын газар
7	Шатахуун түгээх станц
8	Хүүхдийн тоглоомын газар
9	Нийтийн тээвэр
10	Зочид буудал, жуулчны бааз
11	Нийтийн хоолны газар
12	Дэлгүүр, бөөний худалдааны төв

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.

"Төрийн Мэдээлэл" эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12,

Төрийн ордон

☎ 265958

Индекс 14003

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын

Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 267457

Хэвлэлийн хуудас 2